

НИЙТИЙН СОНСГОЛ

НИЙТЛЭГ ТОХИОЛДДОГ АСУУЛТУУДЫН ХАРИУЛТ



НИЙТИЙН СОНСГОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Хууль тогтоох, шийдвэр гаргах үйл явцад иргэд, иргэний нийгмийн байгууллага, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн болон хувийн хэвшлийн байгууллага, төрийн байгууллага гэх мэт төрөл бүрийн салбарынхан оролцон байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх үйл явцыг НИЙТИЙН СОНСГОЛ гэнэ. Товчхондоо төрийн шийдвэр гаргах үйл явцад дээр дурдсан талууд байр сууриа илэрхийлэн оролцож, шийдвэр гаргагч тэднийг СОНСОХ үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Төрчлэн шийдвэр гаргагч гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг хянахдаа тухайн шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагааг хянах зорилгоор мөн шийдвэр гаргагч сонсгол зохион байгуулж болох ба үүнийг ХЯНАЛТЫН СОНСГОЛ гэж нэрлэдэг.



НИЙТИЙН СОНСГОЛ ЭНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ЮУГААРАА ЯЛГААТАЙ ВЭ?

Хамгийн гол нэг ялгаа нь сонсголын явцад аль болох олон хүнд байр сууриа илэрхийлэх боломж олгох үүднээс энгийн хэлэлцүүлгийн үеийнх шиг талууд мэтгэлцэх, харилцан ярилцах, санал бодлоо солилцох боломж байдаггүй. Сонсголд оролцогчид тодорхой журам, дэгийн дагуу, ихэвчлэн хурал даргалагчийн зүгээс оролцогчдын тоог харгалзан тогтоосон хугацаанд багтаан эрэмбэ дараалал, эмх цэгцтэйгээр байр сууриа илэрхийлэх хэлбэрээр явагддаг.



НИЙТИЙН СОНСГОЛЫГ МОНГОЛ УЛСЫН ЯМАР ХУУЛЬ, ТОГТООМЖИД ТУСГАН ЗОХИЦУУЛЖ БАЙГАА ВЭ?

2015 оны 7 сарын 8-ны өдөр Улсын Их Хурал (УИХ)-аар батлагдаж 2016 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж байгаа Нийтийн сонсголын тухай хууль

Хуульд ямар нөхцөлд нийтийн сонсгол явуулах, сонсгол зохион байгуулах шийдвэрийг хэн гаргах, хэрхэн зохион байгуулах гэх зэрэг асуудлыг тусган зохицуулжээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8-р бүлэг

УИХ-аас зохион байгуулах нийтийн сонсголын дэг журмыг т зааж зохицуулдаг.

УИХ-аас 2017 оны 12-р тогтоолоор баталсан "Нийтийн сонсголын зохион байгуулах журам"

Хяналтын зорилгоор явуулж буй Сонсголыг энэ журмаар зохицуулж байна.


Захиргааны ерөнхий хуулийн 26 болон 27-р зүйл (захиргааны акт, захиргааны гэрээ), 74-76-р зүйл (төлөвлөлт)

Захиргааны шийдвэр, төлөвлөлттэй холбоотой сонсголыг тус тус зохицуулж байна.

 Ямар нөхцөлд зайлшгүй сонсгол хийхийг хуульчилсан байдаг вэ?
Хэн санаачилж, зохион байгуулах вэ?

СОНСГОЛ ЯВУУЛАХ НӨХЦӨЛ	СОНСГОЛЫН ТӨРӨЛ	ХЭН САНААЧЛАХ ВЭ?
Эрх бүхий этгээдээс хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт боловсруулахад	Хууль тогтоох сонсгол, Захиргааны хэм хэмжээний	Иргэн хуулийн этгээд хүсэлт гаргаж болох ба УИХ-ын байнгын хорооны нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар
Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилт, тэдгээрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагааг хянах болон хүний эрхийн асуудлыг авч хэлэлцэхэд	Ерөнхий хяналтын сонсгол	Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүдийн ¼, ИТХ-ын гишүүдийн ¼-ээс доошгүй нь, Байнгын хорооны гишүүдийн олонх хүсэлт гаргаснаар, түүнчлэн иргэд, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийг байнгын болон дэд хороо, иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид хэлэлцэн хүлээн авсан бол
- Татварын хууль тогтоомж болон төсөв батлах, төсвийн орлого ба зарцуулалтад хяналт тавих - Засгийн газрын тусгай сан, Нийгмийн даатгалын сан, Хүний хөгжлийн сангийн төсөв, Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл, зээл, буцалтгүй тусламж, баталгаа гаргах болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа шийдвэр	Төсвийн хяналтын сонсгол	- Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, УИХ-ын гишүүдийн ¼ хүсэлт гаргасан бол түүнчлэн, - Засгийн газар, яамд, засаг дарга, ИТХ жил бүр зохион байгуулна.
Дэд бүтэц, хот байгуулалт, авто зам, газар зохион байгуулалт, усны байгууламж, хог хаягдлын цэг, зам гудамж талбай, нийтийн эзэмшлийн байгууламж, цогцолбор байгуулах талаар захиргааны шийдвэр	Төлөвлөлтийн сонсгол	Төлөвлөгөө боловсруулж байгаа төрийн захиргааны байгууллага тухай бүр заавал
УИХ-аас томилогдох албан тушаалтны асуудал	Томилгооны сонсгол	УИХ-ын гишүүдийн ¼ хүсэлт гаргаснаар зохион байгуулна.
Тухайн орон нутагт холбогдох асуудлаар	Орон нутгийн сонсгол	УИХ, Засгийн газар асуудалд хамаарах орон нутагт очиж зохион байгуулна.

СОНСГОЛЫН ҮЙЛ ЯВЦ БА ДАРААЛАЛ




Иргэд, иргэний нийгмийн байгууллагууд холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан сонсгол явуулах хүсэлт гаргаж болох уу?

Хүсэлт гаргахад юу анхаарах ёстой вэ?

Болно. Хүсэлт нь Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх ба сонсгол зохион байгуулах үндэслэл шаардлагыг тодорхой тайлбарласан байх ёстой. Тэрчлэн сэдэв, зорилго, товын талаарх саналаа тусгаж болно. Сонсголын төрлөөс шалтгаалаад Нийтийн сонсголын тухай хуулийн 7.1, 8.4-д заасан шаардлагыг мөн хангах шаардлагатай болно. Тухайлбал, ерөнхий хяналтын сонсгол явуулах тухай хүсэлт гаргаж буй иргэн болон хуулийн этгээд "өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн хөндөгдөж байгаа тухай" тайлбарласан байх ёстой.

Оролцогчдод сонсголын зар, мэдэгдэл, урилга хүргэхэд юуг анхаарах шаардлагатай вэ?

Товыг олон нийтийн телевиз, радио болон сонсгол зохион байгуулагчийн цахим хуудас, өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сонсгол эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө олон нийтэд мэдээлнэ. Сонсголын үйл явцад үр бүтээлтэй оролцох боломж нээх үүднээс иргэдэд сонсголын зар, мэдэгдэл, урилгад сонсгол болох огноо, цаг, байрлалыг тодорхой дурдах хэрэгтэй. Түүнчлэн оролцогчдыг хэрхэн бүртгэх, бүртгэл дуусах хугацаа, сонсгол хийх асуудал буюу шийдвэрийн төсөл, үндэслэл, сонсголын журам, дэг, бусад шаардлагатай мэдээллийг хавсаргах, эсвэл хаанаас олж үзэх боломжтойг тодорхой дурдсан байх шаардлагатай.



Сонсголд оролцогч, тэдний эрх үүрэг юу вэ?

ОРОЛЦОГЧ	ЭРХ ҮҮРЭГ
Хүсэлт гаргагч - өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тухай болон сонсголыг зохион байгуулах үндэслэл, шаардлагыг тодорхойлсон этгээд Шинжээч, ажиглагчид	- Тайлбар, санал, дүгнэлт гаргах; - Сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах; - Сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонсголд хүрэлцэн ирэх; - Сонсгол явуулах журам, дэгийг сахих; - Сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх; - Сонсголын асуудлаар гаргасан тайлбар, санал, дүгнэлт нь үнэн бодитой байх.